



ТӨВ АЙМГИЙН БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

ТАБ-ын Дарга, тэргүүлэх аудитор

Л.Жаргалсайхан

И-мэйл: jargsaihan_tuv@yahoo.com

Утас: 70272582

Факс: 01-272-22582

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудитын менежер:

О.Амаржаргал

И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Утас: 70273465

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273465 99018619

И-мэйл: maits2009@yahoo.com

Аймгийн аудитын газрын хаяг:

Төв аймаг Зуунмод сум 1-р баг

Төрийн байгууллагуудын ордон

Цахим хуудас: www.audit.mn

2015 оны 3 дугаар сар

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.3, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Баянцагаан сумын ЗДТГазрын төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд ТӨВ-2015/22/СТА-ТТЗ

аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Баянцагаан сумын ЗДТГазрын төсвийн 2014 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Баянцагаан сумын ЗДТГазрын 2014 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2015 оны 03 дүгээр сарын 14-наас 2015 оны 03 дүгээр сарын 16-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитын багийн гишүүн аудитор Т.Майцэцэг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Баянцагаан сумын ЗДТГазрын 2014 оны төсвийн санхүүгийн тайланг 2015 оны 03 дугаар сарын 12-нд ТАБ-т ирүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллага аудитыг 2015 оны 03 дүгээр сарын 14-наас 2015 оны 03 дүгээр сарын 16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2015 оны 03 дугаар сарын 16-нд Төв аймгийн Баянцагаан сумын ЗДТГазрын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд ЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан “Үндсэн хөрөнгөд элэгдэл тооцох тухай” журмыг 2014 оны 297 дугаар тогтоолоор хүчингүй болгосон байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дүгээр зүйлийн 1-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба нь

Тамгын газар байх бөгөөд дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ.” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тус хуулийн 33 дүгээр зүйлд тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 6.2.-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах үйл ажиллагааг төсвийн болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.38-д “төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” гэж заасны дагуу Төв аймгийн Баянцагаан сумын ЗДТГазрын дарга Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг сумын ИТХурлаас баталж аймгийн Төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиуд, Төсвийн тухай хуулийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, НББ-ийн тухай хуулийн 7.6, 9.1, Сангийн сайдын 2014 оны 122-р тушаал Төсвийн хэмнэлтийн горимд шилжих тухай заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд,УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төв аймгийн Баянцагаан сумын ЗДТГазрын төсвийн 2014 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс Төв аймгийн Баянцагаан сумын ЗДТГазрын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын 10 горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын даргын тушаалаар баталж албажаагүй байна. Бүртгэлийн асcolous програм ашигладаг байна.

Төсвийн шууд захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төв аймгийн Баянцагаан сумын ЗДТГазрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын ажлын хэсэг нь хөрөнгийн тооллого, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт зэрэг санхүүгийн механизмыг бүхэлд нь хянадаггүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Төв аймгийн Баянцагаан сумын ЗДТГазрын Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Баянцагаан сумын ЗДТГазар нь Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 2014 онд батлагдсан төлөвлөгөөгөөр 218511.3 мянган төгрөг зарцуулахаас 200543.7 мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төлөвлөгөөнөөс 17967.6 мянган төгрөг дутуу зарцуулсан. Түлш халаалтын зардлаас дотоод албан томилолт -500.0 мянган төгрөг, урсгал засварт 2500.0 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан. Сумын ИТХ-ын 2014.05.16-ний өдрийн 02 тоот тогтоолоор 2013 оны төсвийн шилжих үлдэгдлээс 6843.3 мянган төгрөгийг буюу ЗДТГазрын төсвийг 5422.3 мянган төгрөгөөр тодотгосон байна.

ЗДТГазрын нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар 74554.7 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж зарцуулаагүй үлдэгдэл 2640.9 мянган төгрөгийг сумын орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлж авлага үүсгэсэн.

Баг нь орон нутгийн төсвөөс 50262.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал зардалд 49186.7 мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвөөс 1076.0 мянган төгрөгийг дутуу зарцуулсан ба 484.5 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын болон нарийвчилсан 9 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Эдгээр эрсдэлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн

хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төв аймгийн Баянцагаан сумын ЗДТГазрын төсвийн 2014 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад цаг хугацааны хязгаардагдмал байдлаас шалтгаалан үндсэн цалингийн зардлыг дүнгээр тулган шалгасан ба санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний 200.0 мянган төгрөгөөс дээш дүнтэй ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/ Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 89.8 хувийг эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн балансын үлдэгдлийг тодруулга тайлан, журнал, тооллогын бүртгэлтэй тулган шалгахад Г.Өлзийбуян даргатай тооллогын комисс нь тооллогын бүртгэлд гарын үсэг зураагүй, дүнг буруу бичсэн, үндсэн хөрөнгийн дансад нийт 286733.3 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгээгүй орхигдуулсан байна. ТБОНӨТХуулийн 72.4.4-д комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Тооллогын комисс нь 286733.3 мянган төгрөгийн хөрөнгийг тоолоогүй, тооллогын бүртгэлд гарын үсэг зураагүй, дүнг буруу бичсэн зөрчлийг арилгуулж, тооллогын комиссын гишүүдэд арга хэмжээ тооцож ирүүлэх албан шаардлага бичих.

2. Сумын ИТХурлын балансад бүртгэлтэй 1211.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг ямар ч шийдвэргүйгээр шилжүүлэн орлогодсон. Санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн шууд захирагчийн үндсэн хөрөнгийг шийдвэргүйгээр бүртгэснийг ИТХуралд оруулан шийдвэрлүүлж хариу ирүүлэхээр зөвлөмж өгөх

3. Сумын 90 жилийн ойтой холбогдуулан Монгол чек металл ХХК хандиваар задгай талбайг 63000.0 мянган төгрөгөөр, ОНХСан хандивын хөрөнгөөр хийсэн зээрд морины хөшөө12420.0 мянган төгрөгөөр тус тус бусад үндсэн хөрөнгө дансанд

хөрөнгийн ангилалыг буруу ангилан бүртгэсэн байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9.1-д заасан “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана”, Сангийн сайдын 2005 оны 276-р тушаалаар батлагдсан дансны нэгдсэн жагсаалтын зааврыг тус тус зөрчсөн

Шийдвэрлэсэн: Буруу ангилан бүртгэсэн хөрөнгийг залруулах албан шаардлага бичих

4. Тайлант онд ЗДТГазар 3811.1 мянган төгрөгийн авлагыг шинээр үүсгэсэн. Нийт авлагыг задалбал ОНӨОрлогоос 2640.9 мянган төгрөг, Мөнхсүхээс 369.0 мянган төгрөг, эзэнгүй билетийн авлага 800.0 мянган төгрөг байна.

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчлийг таслан зогсоох өр авлагыг барагдуулах талаар зөвлөмж өгөх

5. Ерөнхий журналаас аж ахуйн материал 350402 дансны орлогын 4923.6 мянган төгрөгийн гүйлгээг 100 хувь сонгож шалгахад 2072.6 мянган төгрөгийн буюу 42 хувийн бараа материалыг буруу ангилан бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалын 4.16 Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг стандартыг мөрдөнө. Сангийн сайдын 2005 оны 276-р тушаалаар батлагдсан дансны жагсаалт зэргийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалын 4.16 –д заасны дагуу бараа материалыг үнэн зөв ангилан бүртгэх талаар зөвлөмж өгөх

6. Багийн төсвөөс 2014.12.01-нд Эрдэнээгээс 4.3 м3 мод, мөн өдөр МДи-Эс ХХК-аас 6 м3 модыг нийт 1133.0 мянган төгрөгөөр орлогодсон ба өдөрт нь шаардах хуудсаар 100 хувь зарлагдсан ба шаардах хуудас, орлогын баримтын тоо засвартай гарын үсэг тамга тэмдэг дутуу, зарлагын баримт бичдэггүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 4.1.2-д санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх; 7.6-д Анхан шатны баримтын бүрдэлт, үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Бараа материалын анхан шатны баримтын бүрдүүлэлт, хөрөнгийн тооллого тооцоо бодолтыг НББ-ийн тухай хууль, ТБОНӨТухай хууль, НББ-ийн бодлогын баримт бичигт тусгасны дагуу хийж зөрчлийг арилгах зөвлөмж өгөх

7. Батлагдсан орон тоог хэтрүүлэн МЭҮАлбаны мэргэжилтэнд Хөдөлмөр эрхлэлтийг хариуцуулан 30 хувийн буюу 121247 төгрөгийг 2-р сараас олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.3-д батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох, 41.2.2-д батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах, Засгийн газрын 2011.01.25-ний өдрийн 20-р

тогтоолын дагуу сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог батлах тухай Төв аймгийн Засаг даргын 2012 оны А/324 тоот захирамж, Төсвийн хэмнэлтийн горимд шилжих тухай Сангийн сайдын 2014 оны 122-р тушаалыг тус тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн: Батлагдсан орон тоог хэтрүүлэн МЭҮАлбаны мэргэжилтэнд Хөдөлмөр эрхлэлтийг хариуцуулан 30 хувийн буюу 121247 төгрөг нийт 1080.3 мянган төгрөгийг гарт олгосонд төлбөрийн акт тогтоох

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Байгууллагын НББ-ийн бодлогын баримт бичгийг авчраагүй аймгийн СТСХэлтсээс өгсөн НББ-ийн бодлогын баримт бичиг хэвлэмэл ном ашигладаг байна. НББ-ийн тухай хуулийн 17.2. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллана гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: НББ-ийн бодлогын баримт бичгийг санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн шинэчлэн боловсруулж мөрдөх зөвлөмж өгөх

2. Байгууллагын харилцах данснаас бэлэн мөнгөөр авсан 13562.1 мянган төгрөгийн ажил гүйлгээний дансны бичилтийг буруу хийсэн, бэлэн мөнгөний тайланг цаг хугацаандаа гаргадаггүй, тайлан гаргалт хангалтгүй, кассын орлогын ордер огт бичээгүй, зарлагын ордер, гарын үсэг, тамга тэмдэг дутуу, кассын тооцоо бодсон актаар зарцуулаагүй үлдэгдэл 369.0 мянган төгрөгийг авлагаар тайлагнасан Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276-р тушаалын 1-р хавсралтаар батлагдсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 3.10-д мөнгөн кассаар дамжуулан хийгдэх гүйлгээ бүрт орлого, зарлагын баримтыг бичнэ, 7.2-д ... кассын тайланг гаргаж ...дараагийн ажлын өдрийн 12 цагаас хэтрүүлэхгүйгээр ня-бо-д шилжүүлэн өгч хянуулж байна гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: 369.0 мянган төгрөгийн кассын зарцуулаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоох

3. Нэмэлт санхүүжилтийн харилцах дансны мөнгөн гүйлгээний тайлангийн орлогын дүнг журналын дүнтэй тулган шалгахад Орлогын дансны хуулгаар 76973.4 мянган төгрөг орлого төвлөрснөөс буцсан гүйлгээ, НДШ-ийн орлого нийт 8458.7 мянган төгрөгийг бууруулах бичилт хийж 68514.7 мянган төгрөгийн орлого төвлөрсөн. Журналиар 6000.0 мянган төгрөгийг орон нутгийн орлогын данснаас санхүүжүүлсэн ба 74514.7 мянган төгрөгөөр тайлагнахыг 73554.7 мянган төгрөг ба 960.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь орлого зарлагын гүйлгээг бууруулах бичилт хийсэн тул залруулах санал өгсөн. Энэ нь Засгийн газрын 2012 оны 205-р тогтоол ТСанийн

үйл ажиллагааны журам 7.11-д Тухайн байгууллагын данснаас дараах тохиолдолд орлого бууруулах гүйлгээ хийхийг зөвшөөрнө 7.11.3, 7.11.4 –д заасан заалтыг зөрчсөн байна

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулах саналын дагуу алдаа залруулаагүй болно.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын хугацааны шалтгаанаас аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй хөрөнгийн тооллогыг ажиглах, үндсэн хөрөнгөөс түүвэрлэн хяналтын тооллого хийх асуудлыг завсрын аудитаар нөхөн шалгахаар тогтоов.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төв аймгийн Баянцагаан сумын ЗДТГазрын төсвийн 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 372790.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 1449.3 мянган төгрөгийн төлбөрийн акт, 365964.4 мянган төгрөгийн албан шаардлага, 4416.7 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох өвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төв аймгийн Баянцагаан сумын ЗДТГазрын төсвийн 2013 оны санхүүгийн тайланд Төв аймгийн Аудитын газраас 5 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжийн 2 буюу 40 хувийг хэрэгжүүлж, 3 буюу 60 хувийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээрх алдаа, зөрчлийг эс тооцвол Төв аймгийн Баянцагаан сумын ЗДТГазрын төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 9 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Т.МАЙЦЭЦЭГ

2015 оны 03 сарын 15